

ТӨРИЙН АУДИТ



**Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн
Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан**

2017.01.16

Гарчиг

Товчилсон үгийн тайлбар.....	3
Удирдлага зохион байгуулалт.....	4
Санхүүгийн тайлангийн аудитын талаар.....	5
Гүйцэтгэлийн аудитын талаар.....	6
Нийцлийн аудитын талаар.....	9
ИТХ болон өөрсдийн санаачлагаар хийсэн аудитын талаар.....	10
Төлөвлөгөөт бус аудитын талаар	11
Дотоод ажлын талаар.....	12
Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар.....	14
Дүгнэлт, санал.....	15

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
ОХУ	Оросын холбооны улс
ТАТХ	Төрийн аудитын тухай хууль
СУГ	Стратеги удирдлагын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
САГ	Санхүүгийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
УБ	Улаанбаатар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МНБ	Монголын мэргэшсэн нягтлан бодогч
УБСГ	Улсын бүртгэл, Статистикийн газар
ХААА	Худалдан авах ажиллагааны алба

ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт

Дорнод аймгийн Аудитын газар нь 2016 онд МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан ҮАГ-ын 2013-2018 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд үндэслэн аймгийн Аудитын газрын 2016-2018 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөг боловсруулан баталсан.

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 42 ажил, үйлчилгээг 7 багцад хуваан хийхээр төлөвлөж, **“Ес зүй хариуцлагыг сайжруулах”** зорилтын хүрээнд санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын 3 багийн зохион байгуулалтаар дарга, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор-2, ахлах шинжээч, аудитор, шинжээч-4, жолооч гэсэн 11 орон тоотой ажиллалаа.

ҮАГ-ын хэмжээнд нэгдсэн удирдамжаар хийхээр төлөвлөгдсөн аудитууд орон нутаг дахь байгууллагуудад тухайн сэдвийн хамрах хүрээнээс шалтгаалж харилцан адилгүй хуваарилагддаг.

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитууд нь ҮАГ-т цаг хугацаа, хүн хүчний хувьд тусдаа төлөвлөгдөн гүйцэтгэгддэг ч Дорнод аймаг нь газар зүйн байршил, бүс нутгийн онцлогоос шалтгаалж ихэнх аудитуудын сэдвийн хамрах хүрээнд байдгаас, ажилтнууд нэг цаг хугацаанд 2-оос багагүй аудитыг хавсран болон хамтран гүйцэтгэж байна. Мөн төлөвлөгөөт бус аудитууд ч нэмэгдэж байгаа нь аудитын чанар, хүний нөөцийн зохион байгуулалт, ажлын ачаалалд ч нөлөөлж байгаа тул орон тоог нэмэгдүүлэх шаардлага байнга бий болж байна.

Ажлын ачаалал их байгаа хэдий ч ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулахын тулд санхүүгийн тайлангийн аудитын явцад хугацаат үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн 4 ажилтанд дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж сануулах болон цалингийн хувь бууруулах арга хэмжээ авлаа.

Мөн хамт олноо манлайлан сайн ажилласан аудитын менежер В.Цэнгэлмааг Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдэгээр, ахлах шинжээч Ж.Баяртуул, шинжээч М.Ухаанбилэг нарыг аймгийн хүндэт жуух бичгээр, аудитын менежер болон ахлах аудиторыг цалингийн 50 хувиар урамшуулж ажиллалаа.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг багц тус бүрээр авч үзвэл:

- ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийх гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн аудитын 1,2,3-р багц ажлуудад тусгагдсан 22 аудитыг бүрэн хийж, мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан нам, эвсэл, нэр дэвшигчдийн аймаг, сумдын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрт нийцлийн аудит хийж, нийт аудитаар 11,9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс, 32,1 сая төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт тогтоож, 5,4 тэрбум төгрөгийн зөрчилд 79 албан шаардлага өгч нийт 142880 хүн/цаг зарцууллаа.
- Өөрсдийн төлөвлөгөөгөөр хийх аудитын 4-р багц ажилд тусгагдсан Улсын бүртгэлийн хэлтсийн иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжид гүйцэтгэлийн аудит, Гадаадаас ажил хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомж, Газрын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт 2.0 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс, 20,1 сая

төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон төсөвт бүрэн төвлөрүүлэн, 1,4 тэрбум төгрөгийн зөрчилд 44 албан шаардлага өгч санхүүгийн бус 4 үр өгөөж бүртгэн 7728 хүн/цаг зарцуулан ажилласан.

- Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний 5-р багцад тусгагдсан Дорнод аймгийн 2017 оны төсвийн орлогыг 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 942,7 сая төгрөгийн зарлагын үр ашгийг сайжруулах дүгнэлт саналыг хэлэлцүүлснээс 415,0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлж, зардлын үр ашиг сайжруулах саналаа тусгуулж ажилласан. Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд нам эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг УАГ-аас ирүүлсэн аргачлалын дагуу тооцон тогтоож хуулийн хугацаанд нь аймгийн ИТХ-д хүргүүлсэн. Мөн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон эрхийн хүрээнд аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийж Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн 105, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд 2, мөн 82 нэр дэвшигч, 2 намын зардлын гүйцэтгэлийг Сонгуулийн тухай хуулийн дагуу нийтэд мэдээлж ажилласан.
- Мэргэжил, арга зүй, шинжилгээний 6-р багцад тусгагдсан 7 ажлаас, 6 ажил бүрэн хийгдэж, Төрийн аудитын байгууллагын баримтлах чиглэлд нийцүүлэн Аудитын газрын бодлогын баримт бичиг, мөрдөгдөж буй хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц орон нутгийн онцлогт тохирсон заавар, гарын авлага боловсруулах ажил хэрэгжүүлээгүй нь МУЕА Төрийн аудитын хэмжээнд аудитын төрөл тус бүрээр болон акт, албан шаардлагын журмуудыг 100 хувь өөрчлөн шинэчилж баталсантай холбоотой.
- Бусад ажлын 7-р багцад тусгагдсан 15 ажлаас 13 ажил бүрэн хэрэгжиж 2 ажил хэрэгжих шатандаа явж байна. Хэрэгжих шатандаа явж буй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах болон байгууллагын 2016 оны төсвийн зарцуулалтад хяналт тавьж зардлыг хэмнэж, санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж УАГ-т хүргүүлэх 2 ажлын хуульд заагдсан хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

Аймгийн Аудитын газар нь 2016 онд төсвөөс авах 220,3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч 220,2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Улс, орон нутгийн төсөвт 66,1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.


Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит

Орон нутаг дахь 206 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулахаас 21 байгууллагад итгэл үзүүлэн, 65 байгууллагыг түүвэрт хамруулан, 119 байгууллагын тайланг баталгаажуулан, санхүүгийн тайлангийн аудитын СТАУС програмд оруулж нийт 27,1 сая төгрөгийн өртөг, 7304 хүн/цаг зарцуулан ажиллалаа. Үүнд: Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 1, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, шууд захирагчийн 74, тусгай сангийн 18, орон нутгийн болон төрийн өмчит үйлдвэрийн

газруудын 12 тайлан хамрагдсан. Цагаан-Овоо сумын Эмийн эргэлтийн сан нь санхүүгийн тайлангаа төсвийн хуульд заасан хугацаанд ирүүлээгүй.

Аудитад хамрагдсан 114 байгууллагуудад зөрчилгүй, Дорнод Их сургууль, Мал аж ахуй Эрдэм шинжилгээний хүрээлэн, Авто тээврийн төв, Халхгол сумын ЗДТГ-т хязгаарлалттай санал дүгнэлт өгч, Халхгол сумын Эмийн эргэлтийн санд дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,8 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4,9 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 6,5 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоон, 1,9 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага, 208 зөвлөмж өгч, нийт 82.7 сая төгрөгийн санхүүгийн 18 үр өгөөж, санхүүгийн бус 2 үр өгөөж бүртгэн ажиллалаа.



Нийт зөрчлийг графикаас үзвэл 7,6 сая төгрөгийн зөрчил орлого бүрдүүлэлттэй, 5,5 тэр бум төгрөгийн зөрчил бүртгэл, тайлагналтай, 297,3 сая төгрөгийн зөрчил хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 222,2 сая төгрөгийн зөрчил арвилан хэмнэлттэй, 132,9 сая төгрөгийн зөрчил төсвийн төлөвлөлттэй, 435,9 сая төгрөгийн зөрчил дотоод хяналттай, 19,8 сая төгрөгийн зөрчил худалдан авалттай, 2,3 тэр бум төгрөгийн зөрчил бусад шалтгаантай холбоотой гарсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллаагүй, хязгаарлалттай болон татгалзсан санал дүгнэлт авсан 6 байгууллагын удирдлагад хариуцлага тооцуулах, ажлаас халах саналыг эрх бүхий албан тушаалтнуудад тус тус хүргүүлсэн.

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудит

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийсэн төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бус 1 аудитад 25 байгууллагыг хамруулан, 21,4 сая төгрөгийн өртөг, 9504 хүн/цаг зарцуулж, нийт 2,6 тэр бум төгрөгийн зөрчил илрүүлснээс 20,4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоон, 960,2 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 38 зөвлөмж өгч, санхүүгийн 20,4 сая төгрөгийн санхүүгийн 4 үр өгөөж, санхүүгийн бус 3 үр өгөөж бүртгэн ажиллалаа. Үүнд:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн



дагуу гүйцэтгэлийн аудит хийж 12 сумын хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь үзэж шалгалаа.

Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 1,2 тэр бум төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 60.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 1,0 тэр бум төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 19.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 899.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага нийт 20 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд Тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд болон аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн, аймгийн ерөнхий нягтлан бодогч нарыг оролцуулан хийж, 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.

2. Дорнод аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудит хийсэн.



Аудитаар 331,9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 6 зөвлөмж өгсөн.

Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг Тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд, Дорнод аймгийн Засаг дарга, аймгийн ерөнхий нягтлан бодогч нарыг оролцуулан хийж, 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.

3. Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, үр дүнд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудит хийсэн.




Аудитаар 9.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 0,4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 9.5 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.



Аудитын явц дахь нөөцийн бараа материалын биет тооллого

Аудитын хэлэлцүүлгийг Тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд, Дорнод аймаг дахь Улсын нөөцийн салбарын даргыг оролцуулан хийж. 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.

4. МУ-ын Их Хурлын болон аймгийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудит хийсэн.



Аудитаар 29.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 1,4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 4 зөвлөмж өгсөн.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийж буй төлөвлөгөөт бус Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн үйл ажиллагааны үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитыг Гүйцэтгэлийн аудитын газартай хамтран хийсэн.

Сонгуулийн тухай хуулийн заалтын дагуу 2016 оны аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийх төлөвлөгөөт бус аудитыг хийн www.audit.mn цахим хуудсанд мэдээлээд байна.

Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудит

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийсэн төлөвлөгөөт 6, төлөвлөгөөт бус 3 аудитад 576 байгууллага, 124 нэр дэвшигчийг хамруулан, 64,6 сая төгрөгийн өртөг, 61824 хүн/цаг зарцуулж, нийт 2,5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс 33,0 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоон, 33,0 сая төгрөгийн санхүүгийн 3 үр өгөөж, санхүүгийн бус 1 үр өгөөж бүртгэж, 2,4 тэрбум төгрөгийн зөрчилд 64 албан шаардлага, 52 зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалтад ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу нийцлийн аудит хийж 12 сумын хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь үзэж шалгалаа.



Аудитаар 49.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,5 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 39,4 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 10 зөвлөмж өгсөн.



Хөрөнгө оруулалтуудын болон Шилэн дансны аудитаар сумдад

Төсвийн тухай хууль, ОНХС-гийн журмыг зөрчин урсгал зардалд зарцуулсан 6,2 сая төгрөгт төлбөрийн актыг тогтоон Хэрлэн сумын ОНХС-гийн дансанд буцаан төвлөрүүлүүлэх албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Өмнөх оны аудитаар тавигдсан төлбөрийн актыг барагдуулаагүй албан тушаалтныг ТАТХ-ын 28.2-т заасны дагуу ажлаас халах саналыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд Тэргүүлэх аудитор, нийцлийн аудитын багийн гишүүд болон аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Худалдан авах ажиллагааны албаны дарга, аймгийн ерөнхий нягтлан бодогч нарыг оролцуулан хийж, 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлэн, audit.mn сайтын Аудитын тайлан хэсэгт байршуулан ажилласан.

2. Тайлант хугацаанд Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу 1, 3 улирлын байдлаар 2 удаагийн давтамжтайгаар нийцлийн аудит хийсэн.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан улсын төсвийн болон аймгийн ТЕЗ, түүний харьяа төрийн болон орон нутгийн төсөвт албан газар, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компани, тэдгээрийн өмчийн оролцоотой давхардсан тоогоор 420 байгууллагыг хамруулав.

2016 оны 1 дүгээр улиралд хийгдсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 97,1 хувьтай байсан бол 2016 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар аудитад 209 байгууллага хамрагдан 96,7 хувьтай хэрэгжүүлж өмнөх аудитын гүйцэтгэлтэй харьцуулахад 0,4 хувь буурсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 14 суманд газар дээр нь очиж үзэн хуулийн хугацаанд тайлагнаагүй хоцроон мэдээлсэн байгууллагуудад мэдээллээ хуулийн хугацаанд байршуулж байх аудитын зөвлөмж, арга зүйгээр ханган 10 байгууллагын 20 албан тушаалтанд хугацаатай албан шаардлагыг өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан.

3. Төрийн аудитын тухай хууль болон Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор орон нутгийн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт төлөвлөгөөт бус сумдын ИТХ-ын сонгуульд оролцох 2 нам, 49 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрт болон сумдын орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн зардлын гүйцэтгэлд 2 нийцлийн аудитыг хийсэн.

Аудитаар 2016 оны аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох 6 улс төрийн нам, 75 бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө ирүүлснээс 30 нэр дэвшигч сонгуульд оролцохгүй болсон шалтгаанаар хөтөлбөрөө буцаан авсан.

Аудитын явцад мөрийн хөтөлбөр дэх хуулийн шаардлагад нийцэхгүй байгаа заалтуудыг залруулах тухай 32 албан шаардлагыг нам, нэр дэвшигчдэд хүргүүлж, 2016.04.20-2016.05.10-ны өдрийн хугацаанд 6 улс төрийн нам, 45 нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлтийг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн. Үүнээс МҮАН-ын мөрийн хөтөлбөрт нийцээгүй дүгнэлт өгч, бусад нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт нийцсэн дүгнэлтийг өгсөн.

Сумдын ИТХ-ын сонгуульд оролцох 2 нам, 49 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлснээс хуулийн шаардлагад нийцэхгүй байгаа заалтуудыг залруулах тухай 10 албан шаардлагыг нам, нэр дэвшигчдэд хүргүүлж, 2016.08.18-2016.09.08-ны өдрийн хугацаанд 2 улс төрийн нам, 49 нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт нийцсэн дүгнэлтийг өгч аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн.

4. Байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн аудитаар аймгийн ИТХ, Баян-Уул сумын Засаг дарга нарт тухайн жилийн төсөв батлахдаа Байгаль орчны тухай хууль журмыг мөрдөж

нөхөн сэргээлтийн зардлыг тусган ажиллах 162,2 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч, нийт 5 зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан.

5. Засгийн газрын тусгай сангийн аудитыг ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу “Байгаль хамгаалах сан”-гийн үйл ажиллагаанд аудит хийж 2 зөвлөмж, “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гийн аудитаар 2,4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 10,5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгөн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Тавдугаар бүлэг. ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудит

Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ болон Дорнод аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудит, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ болон өөрийн санаачлагаар Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний чанар хүртээмжид гүйцэтгэлийн, Гадаадаас авах ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомж, Газрын тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийн нийт 1930,3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, дуудлага худалдаа явуулаагүй олгосон 1,4 тэрбум төгрөгийн газрын гэрчилгээг хүчингүй болгуулах албан шаардлага, 27 зөвлөмжийг хүргүүлэн, 20,1 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулан, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Мөн 2017 оны аудитын төлөвлөгөөнд тусгуулах аудитын сэдвийн талаарх саналыг албан ёсоор аймгийн ИТХ-аас авч ҮАГ-т хүргүүлсэн.

Зургадугаар бүлэг. Төлөвлөгөөт бус аудит

Тайлант онд цаг үеийн шинжтэй ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийж буй төлөвлөгөөт бус 4 аудитад 1 байгууллага, давхардсан тоогоор 4 нам, 131 нэр дэвшигчийг хамруулан, 10,4 сая төгрөгийн өртөг, 1632 хүн/цаг зарцуулан Сонгуулийн тухай хуулийн дагуу нийтэд audit.mn цахим хуудсаар мэдээлж ажилласан.

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн үйл ажиллагааны үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитыг Гүйцэтгэлийн аудитын газартай хамтран 1,4 сая төгрөгийн өртөг, 224 хүн/цаг зарцуулан ажилласан.

2. Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийж Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн 105, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд 2, мөн 82 нэр дэвшигч, 2 намын зардлын гүйцэтгэлд аудит хийн нийтэд мэдээлсэн.

3. Сумдын ИТХ-ын сонгуульд оролцох 2 нам, 49 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлснээс хуулийн шаардлагад нийцэхгүй байгаа заалтуудыг залруулах тухай 10 албан шаардлагыг нам, нэр дэвшигчдэд хүргүүлж, 2 улс төрийн нам, 49 нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт нийцсэн дүгнэлтийг өгч аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн.

4.Сумдын орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн зардлын гүйцэтгэлд нийцлийн аудитыг эхлүүлээд байна.

Долдугаар бүлэг. Дотоод ажил

Сургалт

2016 онд УАГ-аас зохион байгуулсан 4 сургалтад нийт 18 хүн хамрагдсан. Үүнд:

1. СУГ-ын менежерүүд, шинжээчээс бүрдсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй сургалтын баг ирж АДБОУС, арга зүйн талаар сургалт зохион байгуулж Тэргүүлэх аудитор, аудитын менежер болон ахлах, аудитор, шинжээчид бүрэн хамрагдсан.

2. Сонгуулийн зардлын хэмжээ тогтоохтой холбоотой арга зүйн онлайн сургалтыг СУГ-аас зохион байгуулж Тэргүүлэх аудитор, аудитын менежер хамрагдсан.

3. САГ-аас УАГ-т зохион байгуулсан СТАУС-ыг хөгжүүлэх, ГА-ын үе шатны ажлыг цахимжуулахтай холбоотой хэлэлцүүлэгт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр очиж оролцсон.

4. Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар “Төрийн аудитын байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд УАГ-ын СУГ-ын менежер Л.Одгэрэл, З.Ариунзаяа нар сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгаа авч фокус ярилцлагад Тэргүүлэх аудитор, ахлах аудитор болон аудитор, шинжээчид бүрэн оролцсон.

5. МУ-ын Ерөнхий аудиторовн тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэжлийн шалгалтад ахлах аудитор Б.Дэлгэрмаа 95 “А” үнэлгээ авч амжилттай оролцсон.

Бусад мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан 6 сургалтад нийт 7 хүн оролцсоноос Үндэсний архивын газраас УБ хотод зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн сургалтад шинжээч, бичиг хэргийн ажилтан Я.Зориг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа: иргэдийн оролцоо, хяналт, шилэн дансны хэрэгжилтийн сургалтад Тэргүүлэх аудитор Б.Болортуул, нягтлан бодогч Д.Нармандах, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалтад нягтлан бодогч Д.Нармандах, ММНБИ-ээс зохион байгуулсан МНБ-ийн хугацаагүй эрх олгох сургалт, шалгалтад Тэргүүлэх аудитор Б.Болортуул, аудитын менежер В.Цэнгэлмаа, ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү нар хамрагдаж МНБ-ийн хугацаагүй эрх, Тэргүүлэх аудитор Б.Болортуул аудиторовн эрх олгох сургалт, шалгалтад хамрагдан аудиторовн эрх авсан амжилт дүүрэн жил байлаа.

Хамтын ажиллагаа

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд орон нутаг дахь ТАБ-уудтай туршлага солилцох, харилцагч байгууллагуудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, иргэд, олон нийттэй харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлууд тусгагдсан ажил 100 хувь биелсэн.

Дорноговь, Говь-Алтай аймгийн аудитын газруудтай биечлэн туршлага солилцож, Авлигын эсрэг аяны хүрээд аймгийн ИТХ, Худалдан авах ажиллагааны алба, Улсын бүртгэл, Статистикийн газрын хамт олонтой хамтран Центавр тэмцээнийг зохион байгууллаа.

Дорнод Их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн ангийн оюутнуудад Тэргүүлэх аудитор “Төрийн аудитын байгууллагын зорилго, чиглэл” сэдэвт лекц, аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдын сургалтад аудитын менежер оролцож, санхүүгийн тайлангийн аудитын талаар мэдээлэл, арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд audit.mn цахим хуудсанд төв болон аймаг, нийслэлийн аудитын газрууд хийгдсэн аудитуудын тайланг байршуулж

байгаа нь харилцан туршлага солилцох ажлыг хөрөнгө шаардахгүй хийх боломжийг нэмэгдүүлсэн.



Туршлага солилцох цугларалт
/Говь-Алтай, Дорноговь, Дорнод /



Авлигын эсрэг хамтдаа /ИТХ, УБСГ, ХААА/



“Төрийн аудитын байгууллагын зорилго, чиглэл”
сэдэвт оюутнуудад хийсэн илтгэл, лекц



Төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт
санхүүгийн тайлангийн аудитын талаарх мэдээлэл

Иргэд олон нийттэй харилцах, мэдээлэл солилцох зорилгоор 2015 оноос нээн ажиллуулж буй Facebook хуудсанд 2016 онд 55 мэдээлэл байршуулж, иргэд олон нийтээс 33790 хандалт авсан байна. Мөн audit.mn цахим хуудсанд хийсэн аудитуудтай холбоотой мэдээлэл, Шилэн дансны цахим хуудсанд төсөв, санхүүтэй холбоотой мэдээллүүдийг тогтмол байршуулж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудит, Улс орон нутгийн болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтын аудитуудын талаар телевиз, байгууллагуудад 4 удаа мэдээлэл хийлээ.



Төлөвлөгөөнд тусгагдаагүй ч аймгийн хэмжээнд зохион байгуулсан хамт олноороо мод тарих аянд хамрагдаж өмнөх жилийн тарьсан модоо 50-иар нэмэгдүүллээ. Хувийн хэвшлийн Нью эндорфин эмнэлэгтэй хамтын ажиллагаа эхлүүлж ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд үнэ төлбөргүйгээр бүрэн хамрууллаа.

Өргөдөл гомдол шийдвэрлэлт

Иргэдээс төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил шалгуулах тухай 6, тайлан, мэдээлэл авах тухай 2 хүсэлт ирүүлснийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүлэн ажиллаад байна.

Шинэ санаачлага

Ажиллагсдын санаачлагаар хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хамт олныг идэвхжүүлэх зорилгоор 7 хоног бүр волейболын спортоор хичээллэх цаг гарган тогтмолжуулснаар Санхүүчдийн баяраар жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг шилжин явах цомын спортын тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцож анх удаа гар бөмбөгийн тэмцээнд II байр, буухиад II байр тус тус эзэллээ.

Мөн хамтын сангийн хуримтлалыг бий болгосон нь ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зохих хэмжээний дэмжлэг болж байна. Мөн төсвийн нөхцөл байдлаас шалтгаалж мөнгөн хэлбэрийн урамшуулал, тусламж үзүүлж чадахгүй байгаа нөхцөлд ажилтнуудыг хувийн мэдлэг чадвараа дээшлүүлж сургалтад хамрагдах болон эмчилгээ хийлгэх, ар гэрт нь гачигдал гарсан тохиолдлуудад цалинтай чөлөө олгох, хамт олноороо аялах зэрэг дэмжин идэвхжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Наймдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

2016 оны хагас жилийн Санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татвар болон нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох журам зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар илэрхийлэн гарган УАГ-т хүргүүлээд байна.

Тайлант хугацаанд төсвөөс 220,3 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 220,2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцууллаа. Татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангуудыг бүрэн үзүүлэлтээр нь гарган холбогдох газруудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын тайлан мэдээг сар бүр гарган УАГ-т хүргүүлж ажилласан.

Нэгдсэн удирдамжаар хийгдсэн Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитууд болон өөрийн төлөвлөгөөт аудитаар сумдад ажиллахад шаардлагатай томилолт, шатахууны зардлын 5,9 сая төгрөг, урсгал засварт шаардлагатай 5,0 сая төгрөгийг шийдвэрлэж өгөх хүсэлтийг маань ҮАГ цаг тухайд нь шийдвэрлэн төсөвт суулгуулж өгсөн.

Мөн байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган явуулах, ажилчдын ажиллах нөхцөл бололцоог хангах үүднээс Санхүүгийн тайлангийн аудитын СТАУС програмыг ажиллуулахад шаардагдах үзүүлэлт бүхий компьютер, бусад тоног төхөөрөмжийн хэрэгцээг хүргүүлэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 09 дүгээр сарын 26-ны 02 дугаар хуралдаанаар компьютер, тоног төхөөрөмж худалдан авах 10'000'000 төгрөгийг батлуулан суурин компьютер 3, зөөврийн компьютер 1, зөөврийн скайнерь 2, суурин утасны аппарат 3 ширхгээр хангаад байна.

Мөн байгууллагын ахмад ажилтан Д.Жамсран, Б.Жанлавцогзол нар нь гэртээ байнгын хэвтрийн байдалтай, гэр бүлийн хүний асаргаанд, сэтгэл санааны хүнд нөхцөлд байгаад бид аймгийн удирдлагад хүсэлт хүргүүлэн тус бүрд 1,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, жолооч Ч.Алтангэрэл нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсний дагуу төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу 12 сартай тэнцэх хэмжээний 5,2 сая төгрөгийн тэтгэмжийг олгуулсан.

Есдүгээр бүлэг. Дүгнэлт санал

Дорнод аймгийн Аудитын газар нь 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 42 ажлыг бүрэн хийж гүйцэтгээд байна.

Тайлант оны төлөвлөгөөнд тусгагдаагүй ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн үйл ажиллагааны үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитыг Гүйцэтгэлийн аудитын газартай хамтран, Төрийн аудитын болон Сонгуулийн тухай хуулийн заалтын дагуу 2016 оны аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд 9,5 сая төгрөгийн өртөг, 1632 хүн/цаг зарцуулан ажилласан.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж, тайлагнах журмын дагуу СМ1-СМ8 гэсэн 8 төрлийн мэдээ гаргахаас СМ7 буюу дотоод аудитын мэдээ орон нутагт бөглөгдөхгүй тул бусад 7 мэдээг гарган хүргүүлээ.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган явуулахад ашиглагддаг тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын 50-60 хувь нь элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглагдах боломжгүй эвдэрсэн, аудитор, шинжээч нарын 2 компьютер огт ажиллахгүй байгаа бөгөөд аудитын явцад нотлох баримт бүрдүүлэхэд шаардлагатай камер дагалдах хэрэгслүүд огт байхгүй.

Иймд Санхүүгийн тайлангийн аудитын СТАУС програмыг ажиллуулахад шаардагдах үзүүлэлт бүхий компьютер, бусад тоног төхөөрөмжийн хэрэгцээнд шаардагдах төсвийн судалгааг доорх хүснэгтээр гарган хүргүүлж байна.

2016 оны үйл ажиллагааны тайлан

№	хөрөнгийн нэр	Марк	нэг бүрийн хүн	тоо хэмжээ	2017 оны дүн
А. Биет хөрөнгө					
1	Суурин компьютер	Процессор: Dell Optiplex9020MT Core I7/4770 3,4ghz, RAM8Gb8 HDD 1Tb, Card1Gb	1 949 000,00	6	11 694 000,00
	Суурин компьютер	Дэлгэц: DellS2240T 21,5 inch, Multi-Touch LED	699 000,00	1	699 000,00
	Суурин компьютер	DellS2240L 21,5 inch LED	399 000,00	5	1 995 000,00
2	Зөөврийн компьютер	Процессор: Dell Optiplex9020MT, RAM8Gb8 HDD 1Tb, Card1Gb	3 499 000,00	1	3 499 000,00
3	Канон, принтер /олон үйлдэлтэй/	DellS2240T 21,5 inch, Multi-Touch LED	450 000,00	2	900 000,00
	Канон, принтер /олон үйлдэлтэй/	Dell Optiplex9020MT Core I7/4770 3,4ghz, RAM8Gb8 HDD 1Tb, Card1Gb	3 305 900,00	1	3 305 900,00
4	Камер дагалдах хэрэгслийн хамт	Dell	3 999 900,00	1	3 999 900,00
5	Микрофон	-	60 000,00	8	480 000,00
6	Чихэвч	-	60 000,00	10	600 000,00
	дүн				27 172 800,00
Б.Биет бус хөрөнгө					
1	Архивын програм		2 000 000,00	1	2 000 000,00
	дүн				2 000 000,00
	нийт дүн				29 172 800,00

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цааснаас татгалзан цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотойгоор архивын програмтай болгох шаардлагатай байгаа бөгөөд манай байгууллагын хувьд ОХУ-ын хуучин консулын орон сууцны 2 өрөө байранд үйл ажиллагаагаа явуулдаг учраас бичиг баримт, тайлан мэдээгээ хадгалах өрөө тасалгаа байхгүй байна.

Одоогийн байдлаар хийгдсэн аудитуудын тайлан болон бичиг хэргийн файлуудыг сан үүсгэн компьютерт хадгалж байгаа нь архив, бичиг хэргийн стандартын шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд тухайн компьютерийн хүчин чадал, багтаамж муугаас өдөр тутмын ажил гүйцэтгэхэд гацах зэрэг хүндрэл учруулж байна.

Манай аймгийн хувьд газар зүйн байршил, хүн амын нягтаршил, стратегийн орд газруудын хэмжээ, сум, аж ахуйн нэгжийн тоо зэрэг нь бусад аймгуудтай харилцан адилгүй учраас нэгдсэн удирдамжтай аудитууд бүгд хийгддэг. Эдгээр аудитуудыг чанартай үр дүнтэй хийхэд хүн хүч хүрэлцдэггүй учраас аудитыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж чадахгүйд хүрэх хүндрэл үүсдэг учраас зайлшгүй 1 орон тоо нэмэгдүүлж өгөх саналыг хүргүүлж байна.

Манай байгууллага нь төрийн аудитын байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, ёс зүй хариуцлагыг сайжруулахын төлөө хичээн ажиллалаа.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

